

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

2022 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 10 дүгээр сарын 05

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Цахим хөгжлийн багц хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрийг баримтлан 2022 оны 09 дүгээр сарын 01-ээс 09 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллав.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Виз, зөвшөөрлийн чиглэлээр:

1.1.1. Гадаадын иргэнд үзүүлсэн виз, визийн зөвшөөрлийн үйлчилгээ:

Тайлант хугацаанд 2180 гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгож, үүнээс 1607 иргэний визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газарт, хилийн боомтод виз олгох 573 иргэний визийн зөвшөөрлийг хилийн боомт, бүсийн газруудад илгээлээ. (Хүснэгт 1)

Түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн 623 гадаадын иргэнд зохих ангиллын Монгол Улсын виз хилийн боомтод олгосон. Мөн 15 иргэнд гарах-орох цагаачийн мэдэгдэл олголоо. (Хүснэгт 1)

Хүснэгт 1

Визийн зөвшөөрөл		Виз	Оршин суух зөвшөөрөл			Түр ирэгч	
Хилийн чанадад	Хилийн боомтод		олгосон	сунгасан	хэлбэр, төрөл өөрчилсөн	хаягийн бүртгэл	байх хугацаа сунгалт
1607	573	623	1018	862	0	1373	1194
2180							

Энэ сард нийт 1162 аж ахуйн нэгж, байгууллагын 4158 гадаадын иргэний хүсэлтийг цахим (eimmigration.mn)-аар хүлээн авч, холбогдох хууль, журмын дагуу хянан, шийдвэрлэлээ.

Визийн мэдээллийн нэгдсэн сан “evisa.mn” системээр нийт 29 улсын 529 иргэнд цахим виз олгож, 3 улсын 9 гадаадын иргэний визийн хүсэлтэд татгалзсан.


1.1.2. Гадаадын иргэний бүртгэл, хяналт:

Эрх бүхий төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлийг үндэслэн 1018 гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 862 иргэний оршин

суух зөвшөөрлийн хугацааг сунган, оршин суух зөвшөөрөлтэй 606 иргэний бүртгэлд хасалт хийсэн. (Хүснэгт 1)

Гадаадын иргэнийг уригч 47 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу 122 гадаадын иргэнд виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгож, Монгол Улсад түр ирэгчээр ирсэн 1373 гадаадын иргэнийг хаягийн бүртгэлд бүртгэсэн. Мөн Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн болон визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 1194 иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан. (Хүснэгт 1)

График 1



Дээрх тоон үзүүлэлтийг 2021 оны үзүүлэлттэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 57.5 хувь, виз олголт 20.0 хувь, оршин суух зөвшөөрөл олголт 43.5 хувиар тус тус өсөж, оршин суух зөвшөөрлийн сунгалт 11.2 хувиар буурчээ.

“Монгол Улсад оршин суух үнэмлэх” 1456 ширхэг шинээр хэвлэж, 762 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунган, 44 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ.

Оршин суух зөвшөөрлөө сунгуулах хүсэлт ирүүлсэн 89 гадаадын иргэний хүсэлтийг байгууллагын даргын 2 удаагийн тушаалаар шийдвэрлэж, 10 иргэнд регистрийн дугаар олгосон.

1.1.3. Зөвлөгөө, мэдээлэл:

Тайлант хугацаанд гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт, визийн хугацааны сунгалтын асуудлаар нийт 4303 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

1800-1882 утас	Биечлэн	Фэйсбүүк хуудас чат	Автомат хариулагч	Имэйл	Нийт
2692	1091	0	120	401	4304

Түүнчлэн KGB хүргэлтийн үйлчилгээгээр 2 иргэнд паспорт, оршин суух үнэмлэх олгосон байна.

Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвд биечлэн 17 иргэнд, утсаар 82 иргэнд зөвлөгөө мэдээллийн үйлчилгээ үзүүлсэн.

1.2. Иргэний харьяаллын чиглэлээр:

1.2.1. Иргэний харьяалал:

Харьяатын асуудлаар нийт 16 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, 15 иргэн, 1 харьяалалгүй хүний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авах ажиллагааг явууллаа. (Хүснэгт 4)

Хүснэгт 3

Хугацаа	Монгол Улсын харьяат болсон	Иргэний харьяаллыг сэргээн тогтоосон	Монгол Улсын харьяатаас гарсан	Хоёрдмол харьяалалтай иргэнийг бүртгэсэн
09 дүгээр сар	-	-	-	35
2022 он /өссөн дүнгээр/	1	-	-	385

Түүнчлэн 20 иргэний хүсэлт, баримт бичиг, санал, дүгнэлтийг Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 1 иргэн, 3 харьяалалгүй хүний хүсэлт, баримт бичиг, санал, дүгнэлтийг Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн. (Хүснэгт 4)

Хүснэгт 4

Иргэний харьяаллын талаарх сарын мэдээ						
д/	Харьяалах улс	Хүлээн авсан хүсэлт	Түдгэлзүүлж буцаасан хүсэлт	Саналд илгээсэн	ЗГХЭГ-т хүргүүлсэн	ЕТГ-т хүргүүлсэн
Монгол Улсын харьяат болох						
1	Хятад	-	-	-	-	1
	нийт	-	-	-	-	1
Монгол Улсын харьяатаас гарах						
1	Монгол Улс	16	-	15	20	-
	нийт	16	-	15	20	-
Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох						
1	Харьяалалгүй хүн	-	-	1	-	3
	нийт	-	-	1	-	3

Монгол Улсын харьяатаас гарч бусад улсын харьяат болохоор дараах 16 иргэн хүсэлт, баримт бичиг шинээр ирүүлснийг хүлээн авсан байна.

- Бельгийн Хаант Улсын харьяат болох 1;
- Бүгд Найрамдах Болгар Улсын харьяат болох 1;
- Бүгд Найрамдах Солонгос Улсын харьяат болох 1;
- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын харьяат болох 6;
- Япон Улсын харьяат болох 7 иргэн.

“Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 52 улсын 4268 хоёрдмол харьяалалтай иргэн бүртгэлтэй байна.

Тайлант хугацаанд хоёрдмол харьяалал үүсгэсэн 35 иргэнийг “Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д шинээр бүртгэсэн. (Хүснэгт 3)

1.2.2. Хүүхэд үрчлэлт:

09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Монгол Улсаас гадаадын иргэн, гэр бүлд нийт 274 Монгол хүүхдийг үрчлүүлээд байна.

1.2.3. Олон улсын болон гадаад улсад төвтэй төрийн бус байгууллагын бүртгэл, хяналт:

Байгууллагын “Мэргэжлийн зөвлөл”-ийн 09 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа олон улсын болон гадаад улсад төвтэй төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаатай холбоотой 8 байгууллагын асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлэлээ.

- үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон 3,
- зөвшөөрлийн хугацааг сунгасан 4,
- үйл ажиллагааны зөвшөөрлийг хүчингүй болгосон 1.

1.3. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

1.3.1. Гадаадын иргэнд тавих хяналт шалгалт:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэн болон хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг 09 дүгээр сарын 05, 19-ний өдрүүдэд тус тус Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлсэн.

Хүснэгт 5

Зөрчлийн мэдээ (сараар)							
Хувь хүн		Уригч байгууллага			Уригч хувь хүн		
Иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч байгууллага	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч иргэн	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/
20	9,600,000	1	1	390,000	-	-	-
нийт 9,990,000 төгрөг							
Үүнээс гадаадын иргэн							
Хуулийн үндэслэл		Шалтгаан					Гадаадын иргэний тоо
Зөрчлийн тухай хууль 16.2-1.2		нутаг дэвсгэрт оршин суух үнэмлэхийг эзэмших, ашиглах, хадгалах журам зөрчсөн					16
Зөрчлийн тухай хууль 16.2-3.2		оршин суух хугацааг хэтрүүлсэн					1
Зөрчлийн тухай хууль 16.2-3.3		визийн хугацааг хэтрүүлсэн бол хэтрүүлсэн хоног тутам арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно					3
бүгд						20	

Төлөвлөгөөт 1 удаагийн хяналт шалгалтаар 32 гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг шалгахад зөрчил илрээгүй байна.

Төлөвлөгөөт бус 27 удаагийн хяналт шалгалтыг 20 аж ахуйн нэгж, байгууллага, 77 гадаадын иргэнийг хамруулан зохион байгуулж, гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг шалгахад зөрчил илрээгүй.


Тайлант хугацаанд 7 улсын 20 гадаадын иргэн, 1 уригч байгууллага (1 иргэн)-д холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн дагуу нийт 9,990,000 төгрөг (Есөн сая есөн зуун ерэн мянган)-ийн торгох шийтгэл оногдууллаа. (Хүснэгт 5, 6)

Хүснэгт 6

Торгуулсан гадаадын иргэн (тухайн сараар)						
д/д	Харьяалах улс	Зүйлчлэл			Бүгд	Торгуулийн дүн
		16.2-1.2	16.2-3.2	16.2-3.3		
1	Герман	1			1	100,000
2	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хант Улс	3			3	300,000
3	Казахстан			3	3	6,000,000
4	Орос	2			2	200,000
5	Өмнөд Солонгос	3			3	300,000
6	Филиппин	1			1	100,000
7	Хятад	6	1		7	2,600,000
	Нийт	16	1	3	20	9,600,000

Холбогдох хугацааны тоон үзүүлэлтийг 2021 оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 3.1 дахин, зөрчил гаргасан уригч иргэн 2 дахин, албадан гаргасан гадаадын иргэн 50.0 хувь, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 73.9 хувь, саатуулсан гадаадын иргэн 40.0 хувиар тус тус өсөж, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 16.7 хувиар буурсан байна.

График 2



1.3.2. Хориг арга хэмжээ:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 34.2.3 дахь заалтыг үндэслэн 2 улсын 6 иргэний Монгол Улсын хилээр гарах эрхийг байгууллагын даргын 4 удаагийн тушаалаар түр түдгэлзүүлж, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 34.2.3 дахь заалтуудыг үндэслэн тус улсаас гарахыг түдгэлзүүлсэн 3 улсын 6 иргэний хилээр нэвтрэх эрхийг 3 удаагийн тушаалаар сэргээсэн байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.11, 37.1.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн 2 улсын 3 иргэнийг байгууллагын даргын 3 удаагийн тушаалаар албадан гаргахаар шийдвэрлэлээ. (Хүснэгт 9)

Хүснэгт 9

Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний мэдээ (тухайн сараар)				
д/д	Харьяалах улс	Зүйлчлэл		Нийт
		37.1.11	37.1.12	
1	Казахстан		2	2
2	Хятад	1		1
	Бүгд	1	2	3

Тайлант хугацаанд виз, визийн зөвшөөрөлгүй ирсэн үндэслэлээр нийт 12 улсын 347 иргэнийг Монгол Улсын хилээр оруулахгүй буцаасан. Үүнээс:

- Хойд бүс дэх газар виз, визийн зөвшөөрөлгүй ирсэн 8 улсын 339 гадаадын иргэнийг,
- Агаарын замын боомт хариуцсан газар виз, визийн зөвшөөрөлгүй ирсэн 2 улсын 6 гадаадын иргэнийг,
- Баян-Өлгий аймаг дахь хэлтэс виз, визийн зөвшөөрөлгүй ирсэн 2 улсын 2 гадаадын иргэнийг тус тус Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаажээ.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

2.1.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, төлөвлөгөө, тайлан:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний байгууллагад холбогдох арга хэмжээний хэрэгжилтийн явцыг “Төрийн мэдээллийн сүлжээ” (mojha.unelgee.gov.mn) системд байршуулж, тайлагналаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу тус байгууллагад холбогдох хэсгийн 3 дугаар улирлын танилцуулах мэдээ, Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн холбогдох арга хэмжээний 2012-2022 оны мэдээллийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

Шинэ сэргэлтийн бодлого болон төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, тус бодлогоор хэрэгжүүлсэн ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг

байгууллагын даргын 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/173 дугаар тушаалаар байгуулав.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Шуурхай хуралдаан”-аас өгсөн үүрэг, даалгаврын 3 дугаар улирлын биелэлт, байгууллагын 08 дугаар сарын үйл ажиллагааны тайлангийн тоон мэдээг инфографик хэлбэрээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

2.1.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөц, сургалт:

НҮБ-ын “Олон улсын төрийн албаны өдөр”-ийг тохиолдуулан Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх” нь төслийн нэгжтэй хамтран зарласан “Бүтээмжит төрийн байгууллага шалгаруулах уралдаан”-д манай байгууллага шалгарч, шагналыг Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг 09 дүгээр сарын 05-ны өдөр гардууллаа.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөө, цаашид авах арга хэмжээний саналыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1 дэх хэсэгт заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлагдсантай холбогдуулан төв, орон нутаг дахь нэгжийн индексийг байгууллагын даргын 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/161 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан.

Байгууллагын дэргэдэх “Ёс зүйн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнд байгууллагын даргын 09 дүгээр сарын 22-ны өдрийн Б/237 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орууллаа.

Байгууллагын даргын 09 дүгээр сарын 22-ны өдрийн Б/238, Б/239, Б/240, Б/241, Б/242 дугаар тушаалаар Агаарын замын боомт хариуцсан газрын 2, Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн 1, Баруун бүс дэх газрын 1, Дорноговь аймаг дахь газрын 1 нийт 5 албан хаагчид Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41.8 дахь хэсэгт заасны дагуу хилийн боомт, орон нутагт ажилласан хяналтын улсын байцаагчид олгох 5 жил тутмын урамшууллыг тус тус шийдвэрлэв.

“Төрийн албан хаагчийн зарчимч, шударга байдлыг бэхжүүлэх нь” дэд төслийн хүрээнд “Ажлаас халшрах хам шинж, түүнээс урьдчилан сэргийлэх нь”, “Идэвхтэй сонсох ур чадвар” сэдэвт сургалтыг 09 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулж, төв, орон нутаг дахь нэгжийн зарим 20 албан хаагчийг танхимаар, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 09 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулж, төв, орон нутаг дахь нэгжийн 126 албан хаагчийг, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдал, чиг хандлага” сэдэвт сургалтыг 09 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж, 126 албан хаагчийг цахимаар тус тус хамрууллаа.

2.1.3. Олон нийт, хэвлэл мэдээлэл:

Тайлант хугацаанд байгууллагын цахим хуудсанд үйл ажиллагаатай холбоотой 12, цахим сүлжээнд 16 мэдээ, мэдээллийг байршуулж, давхардсан тоогоор нийт 50 мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчиллаа. Байгууллагын цахим хуудас (фейсбүүк, твийтэр), eimmigration систем дэх

мэдээллийг тухай бүр баяжуулж, байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой мэдээ мэдээллийг тогтмол байршуулж байна.

2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

2.2.1. Хууль, эрх зүй:

Гадаадын иргэн, харьяатын газарт холбогдох Монгол Улсын 1 иргэний нэхэмжлэлтэй захиргааны хэргийн хянан шийдвэрлэх анхан шатны 08 дугаар сарын 15-ны өдрийн шүүх хуралдаанаар тус иргэний нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 08 дугаар сарын 15-ны өдрийн “Шуурхай хуралдаан”-наас ирүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг 08 дугаар сарын 24-ний өдрийн 01/1481 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

“Гэрэгэ системс” ХХК-тай байгуулсан 2021 оны 01/11-47 дугаар гэрээг цуцлах мэдэгдлийг 08 дугаар сарын 11-ний өдөр тус аж ахуйн нэгжид хүргүүлсэнтэй холбогдуулан гэрээ дүгнэх уулзалтыг 08 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж, холбогдох албан тушаалтнууд оролцлоо.

2.2.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

Бүгд Найрамдах Солонгос Улсын Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төвтэй хамтран ажиллах “Хамтын ажиллагааны эрмэлзлийн бичиг”-ийг 08 дугаар сарын 16-ны өдөр баталгаажууллаа.

Америкийн Нэгдсэн Улс болон Шведийн Хаант Улсын иргэнд үзүүлэх визийн хураамжийн буцаан олголтын талаарх мэдээллийн англи-монгол хэлний орчуулгыг 08 дугаар сарын 18,23-ны өдрүүдэд бэлтгэв.

“Хууль бусаар оршин суугаа иргэдийг буцаах тухай Монгол Улс болон Бельгийн Хаант Улс, Люксембургийн Их Гүнт Улс, Нидерландын Хаант Улс хоорондын хэлэлцээр болон түүнийг хэрэгжүүлэх тухай протокол”-ын төслийн саналыг 08 дугаар сарын 02-ны өдрийн 03/1350 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Байгууллагын даргын 07 дугаар сарын 05-ны өдөр Бүгд Найрамдах Солонгос Улсын Шилжилт хөдөлгөөний албаны комиссартай хийсэн уулзалтын тэмдэглэлийг 08 дугаар сарын 10-ны өдрийн 01/1385 дугаар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газраас шилжилт хөдөлгөөний салбарт авч хэрэгжүүлэх шинэчлэлийн талаарх танилцуулгыг 08 дугаар сарын 16-ны өдрийн 01/1423 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төвтэй хамтран ажиллах “Хамтын ажиллагааны эрмэлзлийн бичиг”-ийг бүртгүүлэх тухай хүсэлтийг 08 дугаар сарын 29-ний өдрийн 01/1502 дугаар албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.

2.3.2. Дотоод хяналт:

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн стандартын төслийн саналыг 08 дугаар сарын 08-ны өдрийн 03/1377 дугаар, Америкийн Нэгдсэн Улсын ЭСЯ-ны

Улс төрийн хэлтсээс Монгол Улс дахь хүний эрхийн нөхцөл байдлын тайланг боловсруулж байгаатай холбогдуулан байгууллагын холбогдох мэдээллийг 08 дугаар сарын 29-ний өдрийн 01/1504 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлээ.

2.4. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын чиглэлээр:

2.4.1. Архив, албан хэрэг хөтлөлт:

Монгол Улсын иргэний харьяаллын 2018 оны 20 хадгаламжийн нэгжийн 3405 хуудас баримтыг е-архив программд холболоо.

Хууль тогтоомжийн хүрээнд холбогдох албан хаагчид 110 хадгаламжийн нэгжийг түр олгосон баримтын бүртгэлээр олгож, 267 хуудас баримтыг “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулж, бүртгэл хөтөлсөн.

Тайлант хугацаанд байгууллагын даргаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой тушаал 16, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой тушаал 13 буюу нийт 29 тушаал баталсныг цахим хэлбэрт шилжүүлж, архив албан хэрэг хөтлөлтийн программд бүртгэн, хариуцсан албан хаагчдаар үүргийн биелэлтийг хангуулан ажилласан.

Байгууллагад ирүүлсэн нийт 186 албан бичиг (хариутай 77)-ийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд бүртгэлээр шилжүүлэн, нийт 163 албан бичгийг гадагш илгээсэн ба 21 албан бичиг шийдвэрлэх хугацаандаа хянагдаж байна.

2.4.2. Өргөдөл, гомдол:

Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, албан хаагчаас нийт 73 өргөдөл, 5 гомдол ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хүлээн авлаа.

- төв байгууллагад 33 (иргэнээс 24, албан хаагчаас 9) өргөдөл, 5 гомдол;
- боомт, орон нутаг дахь нэгжид 40 (иргэнээс 23, албан хаагчаас 17) өргөдөл.

Үүнээс 64 өргөдөл, 1 гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн, 9 өргөдөл, 4 гомдол хяналтад байна. Хуулийн хугацааг сунгасан, хугацаа хэтрүүлж, шийдвэрлэсэн өргөдөл, гомдолгүй.

2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

2.5.1. Программ хангамж:

Eimmigration.mn системийн нэмэлт хөгжүүлэлтээр гадаадын иргэн оршин суух зөвшөөрлийн мэдээллээ тодорхойлолт хэлбэрээр гарган авч ашиглах боломжтой болгов.

Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох (RNSF) системд баталгаажсан болон баталгаажуулаагүй мэдээллийг тэмдэглэх хөгжүүлэлтийн гүйцэтгэл 70 хувьтай байна.

Визийн мэдээллийн нэгдсэн сан (evisa.mn) системд Консул, ДТГ-ын модуль, тайлангийн хэсгийн хөгжүүлэлтийг гүйцэтгэж байна.

2.6. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

2.6.1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт:

Оны эхнээс 08 дугаар сарын байдлаар (өссөн дүнгээр) 6,218.5 сая төгрөгийн санхүүжилт авч 4,839.0 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, холбогдох санхүүгийн баримт материалыг бүрдүүлж ажиллалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 09 дүгээр сарын батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг 08 дугаар сарын 22-ны өдрийн 01/1454 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

2022 оны эхний хагас жилийн төсвийн шууд захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн баталгаажуулав.

Шилэн дансны тухай хуулийн дагуу (өссөн дүнгээр) төсөв санхүүгийн 251 мэдээ, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 220 мэдээ, бусад 353 мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд www.shilendans.gov.mn сайтад байршуулав.

2.6.2. Орлого төвлөрүүлэлт:

Голомт банканд байрших 1320000052 тоот төгрөгийн дансанд оны эхнээс 08 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон (өссөн дүнгээр) 798.2 сая төгрөг, 1305124929 тоот валютын дансанд 205,928.54 ам.доллар буюу 639.8 сая төгрөгийг тус тус төвлөрүүллээ. Орон нутаг дахь нэгжүүд нийт 2,174.5 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг харьяа орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

Мөн дээрх хугацаанд (өссөн дүнгээр) хүү торгуулийн 9.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Улсын төсвийн 100900012003 тоот харилцах дансанд визийн үйлчилгээний 5 ам.долларын 135.8 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

2.6.3. Худалдан авалт:

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг, тооллого явуулах журмын дагуу байгууллагын үндсэн хөрөнгийн тооллогыг зохион байгуулж, холбогдох программд бүртгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тайлагнан баталгаажуулж, гүйцэтгэл 94.0 хувь “Хангалттай” үнэлүүлэв.

2.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын чиглэлээр:

2.7.1. Хяналт-шинжилгээ:

Төв болон боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн эхний хагас жилийн үнэлгээнд хяналт-шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулан 08 дугаар сарын 19-ний өдрийн 10/48 дугаар дотоод албан бичгээр төвийн нэгжүүдэд, боомт, орон нутаг дахь нэгжүүдэд цахимаар хүргүүлсэн.

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 08 дугаар сарын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 08 дугаар сарын 26-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт цахимаар хүргүүлэв.

Байгууллагад 2022 оны эхний хагас жилд ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга болон шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ хийж, тайланг 08 дугаар сарын 30-ны өдөр холбогдох нэгжүүдэд хүргүүллээ.

Гадаадын иргэний бүртгэл, хяналтын 07 дугаар сарын статистик мэдээг 08 дугаар сарын 04-ний өдрийн 03/1362 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд, байгууллагын 07 дугаар сарын үйл ажиллагааны мэдээг 08 дугаар сарын 04-ний өдрийн 03/1360, 03/1361 дүгээр албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын ахлах зөвлөхөд тус тус хүргүүлэв.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 08 дугаар сарын 18-ны өдрийн “Шуурхай хуралдаан”-д танилцуулах зорилгоор байгууллагын үндсэн үйл ажиллагаа, хүний нөөц, иргэдэд үзүүлж буй цахим үйлчилгээний тоон мэдээг 08 дугаар сарын 17-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт цахимаар хүргүүлсэн.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны өдөр тутмын мэдээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тухай бүр цахим хэлбэрээр хүргүүлж байна.

2.7.2. Аудит, нийцлийн чиглэлээр:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд цахим хуудсанд байршуулсан 07 дугаар сарын тоон мэдээлэлд 08 дугаар сарын 02, 05-ны өдрүүдэд хяналт тавьж ажиллав.

2.8. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Баруун бүс дэх газар Арцсуурь боомтын албаны байрны урсал засвар, Зүүн бүс дэх газар Ульхан боомтын албан хаагчдын амьдрах байрны гадна орчны тохижилт, Баянхошуу боомт дахь албаны байрны гадна талбайн засварыг холбогдох нэгжийн албан хаагчид тус тус гүйцэтгэсэн.

Гадаадын иргэний бүртгэлийн ISM программ 08 дугаар сарын 07-оос 12-ны өдрүүдэд доголдсонтой холбоотой Агаарын замын боомт хариуцсан газар нь виз олгох үйлчилгээг “EMERGENCY” системээр, бүртгэл хасалтын үйлчилгээг зорчигчийн бичиг баримт, уригчийн хүсэлт, хил нэвтэрсэн тэмдэглэгээ зэрэгт тулгуурлан үзүүлсэн бөгөөд тус хугацааны бүртгэлийг программ хэвийн ажиллагаанд шилжсэний дараа нөхөж бүртгэсэн байна.

ДАРГА

Н.УУГАНБАЯР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

Д.МӨНХБААТАР

НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.ГЭРЭЛТУЯА